

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2019 оны 11-р сарын 29**

Тендер шалгаруулалтын нэр: **“Монголросцветмет” ТӨҮГ-т Нүүрсний шүдэт бутлуур шаардлагатай сэлбэг нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/201908717**

**“Монголросцветмет” ТӨҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос нүүрсний шүдэт бутлуур нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **[2017, 2018 он]**

Сангийн сайдын 2013.01.11-ний өдрийн дугаар 07 тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын 4.1.9 дэх заалтын дагуу тендер нээсэн өдрөөр цахим систем Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сангаас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн чадавхийн мэдээллийг авч үнэлгээнд ашиглана.

- Аудитын тайлан ирүүлэх жилийн тоо: [2017, 2018 он]  
Аудитын тайлан эх хувиар, эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар хувь байх шаардлагатай.
- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна
- Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жилд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт эсвэл гэрээ дүгнэсэн акт/гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ нотариатаар баталгаажуулсан хуулбар хувь байх шаардлагатай/
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй байх

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагагүй.**

Тендерийн хамт **1,000,000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 12-р сарын 30-ны өдрийн 10:00** цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба тендерийг **2019 оны 12-р сарын 30-ны өдрийн 10:10 цагт** цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 510 тоот өрөө, утас: 450060 + 168

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ**